



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгох тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлогын баримт бичгийн төрлийг боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлагдсантай холбогдон эрүүл мэндийн талаарх бодлого, стратеги, хөтөлбөр, дэд хөтөлбөр баталсан Эрүүл мэндийн сайдын тушаалуудыг хавсралтаар хүчингүй болсонд тооцугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан хүчингүй болсон бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шинээр болон шинэчлэн боловсруулах үндэсний хөтөлбөр, дэд хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэхийг яамны газар, хэлтэс, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт тус тус даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 03 сарын 06-ны өдрийн
А/8/ дугаар тушаалын хавсралт



**Хүчингүй болсонд тооцох Эрүүл мэндийн сайдын
тушаалын жагсаалт**

Д/д	Бодлогын баримт бичгийн нэр	Эрүүл мэндийн сайдын тушаалын нэр, огноо
1	Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого	Эрүүл мэндийн сайдын 2011 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн "Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай" 50 дугаар тушаал
2	Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого	Эрүүл мэндийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн "Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлого батлах тухай" 176 дугаар тушаал
3	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлого	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлого батлах тухай" 55 дугаар тушаал
4	Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги	Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2009 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн "Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги батлах тухай" хамтарсан 283 дугаар тушаал
5	Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги	Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн "Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги батлах тухай" хамтарсан 303/126 дугаар тушаал
6	Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх стратеги	Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Стратеги батлах тухай" 448 дугаар тушаал
7	Бөөр хамгаалах үндэсний стратеги	Эрүүл мэндийн сайдын 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн "Бөөр хамгаалах үндэсний стратеги батлах тухай" 243 дугаар тушаал
8	"Эмнэлгийн яаралтай тусламжийн шинэчлэл" стратеги	Эрүүл мэндийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Эмнэлгийн яаралтай тусламжийн шинэчлэл стратеги батлах тухай" 496 дугаар тушаал
9	Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд стратеги	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд стратеги батлах тухай" 84 дүгээр тушаал
10	Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх стратеги	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх стратеги батлах тухай" 183 дугаар тушаал

11	Эмийн аюулгүй байдлын хяналт, тогтолцоог үнэлгээний бэхжүүлэх стратеги	Эрүүл мэнд, спортын сайдын 2014 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн "Эмийн аюулгүй байдлын хяналт, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх стратеги батлах тухай" 365 дугаар тушаал
12	Зайлсхийж болох сохрол, хараа сулралаас сэргийлэх, хянах стратеги, төлөвлөгөө	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Зайлсхийж болох сохрол, хараа сулралаас сэргийлэх, хянах стратеги, төлөвлөгөө батлах тухай" 419 дүгээр тушаал
13	Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах стратеги	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах стратеги батлах тухай" 426 дугаар тушаал
14	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлогыг 2015-2019 онд хэрэгжүүлэх стратеги	Эрүүл мэндийн сайдын 2015 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн "Стратеги батлах тухай" 181 дүгээр тушаал
15	Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн 2015-2020 оны стратеги	Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн "Стратеги батлах тухай" 86 дугаар тушаал
16	Эх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих стратеги	Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн "Эх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих стратеги батлах тухай" 325 дугаар тушаал
17	"Монголын Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх" хөтөлбөр	Эрүүл мэндийн сайдын 2010 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн "Хөтөлбөр батлах тухай" 386 дугаар тушаал
18	Тамхины хор хөнөөлтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр	Эрүүл мэндийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Тамхины хор хөнөөлтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр батлах тухай" 497 дугаар тушаал
19	"Нярайн тандалт шинжилгээний хөтөлбөр"	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн "Нярайн тандалт шинжилгээний (2014-2020) хөтөлбөр батлах тухай" 182 дугаар тушаал
20	Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Хөтөлбөр батлах тухай" 412 дугаар тушаал
21	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" 425 дугаар тушаал
22	Үндэсний эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрт "Эм үйлдвэрлэлийн зохистой дадал"-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр	Эрүүл мэндийн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн "Хөтөлбөр батлах тухай" 337 дугаар тушаал